



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2013 оны 06 сарын 25 өдөр

Дугаар 1/307

Мандалговь

Г

Дэд зөвлөл байгуулах тухай

Монгол улсын Засгийн газрын 2012 оны 07 дугаар сарын 04 –ны өдрийн 222, Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын ажлын албаны 2013 оны 05 дугаар сарын 07-ны өдрийн 1/35 тоотын үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий компани, туслан гүйцэтгэгч аж ахуй нэгжээс орон нутгийн төсөвт төлсөн татвар, төлбөр, хураамж, үйлчилгээний хөлс, ногдол ашиг, торгууль, хандив, тусlamж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан зардлын талаар иргэдэд нээлттэй мэдээлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын дэд зөвлөлийг дараахь бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга – Ш.Энхбат /Аймгийн Засаг даргын орлогч/
Нарийн бичгийн дарга- Ж.Түмэндэлгэр /Аймгийн ЗДТГ-ын ХБХ-ийн ахлах
мэргэжилтэн/

Гишүүдэд: И.Оюун-Эрдэнэ /”Дундговь газар шороо хөдөлгөөн” ТББ/
Д.Мөнхбадрах /Аймгийн байгаль орчны иргэний зөвлөл/
М.Энхбаяр /Аймгийн Байгаль орчны иргэний зөвлөл/
Ц.Цэрмаа /”Чинхаш ХХК”-ний гүйцэтгэх захирал/
И.Чимэдтуяа /”Билэгт хайрхан уул ХХК”-ний тогтвортой амьжиргаа хариуцсан
менежер/

Хоёр. Аймгийн хэмжээнд тусгай зөвшөөрөл бүхий компаниудын хандив, тусlamж, байгаль хамгаалах үйл ажиллагаанд зарцуулсан хөрөнгөнд хяналт тавьж түүний талаарх мэдээ, мэдээлэлийг холбогдох газарт цаг хугацаанд нь хүргүүлж байхыг дэд зөвлөлийн дарга /Ш.Энхбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА С. СУХБААТАР



020000876